

ХЯТАД ХҮНИЙ НЭР ТӨРИЙН ҮЗЭЛ

Хээрийн галуу нисэн үл хүрэх газарт хүмүүн нэр ашгийн тул эрсдэмүй.
(“Гурван зүйлийн үгээр хавсаргасан нэрт эрдэмтний хураасан бичиг”-ээс)

М.ЧИМЭДЦЭЭ*

Хятад орон, хятадын ард түмэн хүн төрөлхтний соёл түүхэнд олон зуун дамнан уламжилсан өдий төдий гайхамшигт соёлын өвийг бүтээж үлдээсэн билээ. Нийтийн он тооллын өмнөх /НОТӨ/ VII зууны үеэс эхлэн үндэс суурийг нь тавьж, XVII зууныг хүртэл үргэжлүүлэн барьж байгуулсан, сансар огторгуйн уудмаас, гараг эрхэсийн чанадаас энгийн нүдээр харагддаг хэмээн хэлцдэг “Түмэн газрын урт хот” (万里长城) буюу “Их цагаан хэрэм”, Мин, Чин гүрний 27 хаан үе залгамжлан барьж байгуулан, заларч сууж ирсэн Гу гун (故宫) буюу “Хааны өвлийн ордон”, НОТӨ 221 онд олон ханлиг улсыг нэгэн дээвэр дор нэгтгэн нэгдсэн төр улсыг анх түрүү байгуулсан Чин Шихуан хаан өөрийн бие хийгээд нэр алдрыг өнөд мөнхлөхүйн зорилгоор 37 жилийн турш барьж байгуулсан “эртний соёл иргэншлийн түүхийн агуу их гайхамшиг” хэмээн нэрлэгддэг “Чин Шихуан хааны морин цэргийн баримал” (秦始皇陵兵马俑), Шаньдун мужийн Чүфү хотноо орших өнө эртний түүхтэй “Күнзийн сүм, ордон, онгон” (孔庙、孔府、孔林) хэмээх цогцолбор, Түвдийн Лхас хотноо сүндэрлэх бурхан номын ариун дагшин ордон “Потала”

(布达拉宫) гэхчлэн олон арван гайхамшиг эдүгээ хүн төрөлхтөний соёлын үнэт өв хэмээн гайхагдаж, дэлхийн чихийг дэлдийлгэж, харааг булааж байдаг бөлгөө. Энэ бүхэн бол хүний гараар бүтээгдсэн гайхамшгууд болой.

Эдүгээ Хятад орон дэлхий дахинаа үүд хаалгаа улам бүр нээж, өдөр хоногоор өөдлөн дэгжиж, эдийн засгийн хүчин чадлаараа Япон улсыг аль хэдийн ардаа орхиж, дэлхийн цээжнээ цолхорон гарч ирэв.

Эрт эдүгээгийн олон гайхамшигийн оньс нууцыг нээж, ойлгож мэдсүгэй хэмээвээс хятадын түүх соёлын уламжлалын гол цөм нь юу болох, хятад хүний оюун санааны ертөнцийн мөн чанар, сэтгэлийн хөөрөл догдлол, сэтгэл зүйн онцлог, сэтгэлгээний хэв маяг, ер нь хятад хүний гол үнэлэмж нь юу болох зэргийг таньж мэдэх нь туйлын чухал болно.

Тиймийн учир эн тэргүүнд авч үзвээс зохилтой нэг чухал ойлголт болвоос “мианзы” (面子) хэмээх ухагдахуун юм. Монголчлон орчуулваас “гадар”, “өнгөн тал”, “нүүр царай” гэсэн шууд утгаас гадна “нэр нүүр”, “нэр төр” “нэр хүнд” (尊严) хэмээсэн шилжсэн утгатай үг болой. Англи хэлний reputation, face, pres-

* М.ЧИМЭДЦЭЭ - МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн багш, хэл бичгийн ухааны доктор (Ph.D), профессор

диге, орос хэлний лицо, честь хэмээх үгстэй дүйнэ.

Хятадын зохиолч Линь Юйтан (林语堂) нэгэнтээ "Хятад орныг ноёрхож буй гурван охин тэнгэр болвоос нэр нүүр, хувь тавилан, ач тус энэ гурав болой" хэмээн нэрлэж, түүний дотор хамгийн хүчтэй нь "нэр нүүр" гэж бичсэн байдаг. Тиймийн учир хятад хүний оюун санааны ертөнцөд нэвтэрч танисугай хэмээвээс эрхбиш "хятад хүний нэр нүүр" (中国人面子心理) хэмээх ухагдахууныг судалж мэдэх шаардлагатай болно.

Эдүгээгээс 100 гаруй жилийн тэртээ Америкийн Христийн шашин дэлгэрүүлэгч Артур Х.Смит /Arthur Henderson Smith (1845-1932)/ хэмээх нэгэн санваартан Хятадад 22 жил амьдран суухдаа, "Хятад хүний зан төрх" хэмээсэн нэгэн ном бичсэн нь өрнө дахинд ихэд алдаршжээ. Тэрбээр уг номдоо хятад хүний зан төрхийн 20 гаруй онцлогийг заан дурдсаны дотор тэргүүн бөлөгт "нэр нүүрээ эрхэмлэдэг" тухай өгүүлж, "хятадад "нэр нүүр" хэмээх ганц үг нь хэрэг дээрээ ээдрээтэй олон үгийн нийлбэр цогц агаад түүний агуулж буй утга санаа нь бидний дүрслэн өгүүлж чадах хийгээд мэдэрч чадах утга агуулгаас хавьгүй гүн гүнзгий юм. "Нэр нүүр" хэмээхүй нь хятад хүний олон чухал зан төрхийн учир битүүлэг цоожийг нээх түлхүүр болой" хэмээн бичсэн байна. Тийнхүү хятад хүний "мианзы" буюу "нэр нүүр" хэмээх ойлголтыг анх түрүү өрнөдөд хөндөж тавьсан түүхтэй юм.

Хожим XX зууны 40-өөд онд Хятадаас Америкт гарсан Ху Сяньзинь (胡先缙) хэмээх хүн судлаач эрдэмтэн хатагтай анх удаа хятад хүний байр сууринаас өрнөдөд энэхүү "нэр

нүүр" хэмээх ухагдахууныг тайлбарласан байна. Тэр цагаас хойш Америкийн нийгэм судлаач Гофман /Goffman/, хүн судлаач Стувэр /Stover/ зэрэг олон эрдэмтэн судлаач хятад хүний "нэр нүүрээ эрхэмлэдэг" сэтгэл зүйг олон талаас нь судалсан боловч эдүгээ хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөн, нийтлэг тодорхойлолт үгүй ажгуу.

Профессор И Жунтянь (易中天) "Нүүр хэмээхүй нь хятад хүний хувьд үнэт эрдэнэ юм. Хятад хүний бараг алив бүхэн нэр нүүрт захирагддаг. Хүмүүс хоорондын харилцаанд нэр нүүрээр аливааг амжуулж, хэвийн харилцана. Нийгмийн харилцаанд бас нэр нүүрээр аливааг шийдвэрлэж, залж хөтөлнө" хэмээн бичжээ. Тиймээс Хятадад хүмүүс хоорондын харилцааны хамгийн чухал хүчин зүйл бол нэр нүүр хэмээн үздэг. Нэр нүүрийг ихэд эрхэмлэхийн учир шалтгаанаар маш олон "жаяг журам" (rules on face) тогтжээ. Тухайлбал, зочин урьж дайлах цайлах л гэхэд бүхэлдээ нэр нүүрийн хэрэг болно. Хэнийг урих, хэнийг эс урих, хэнийг хэр өндөр хүндэтгэлтэй урих, хэнийг үг ярианы завсар хөнгөн мөчид урих зэрэг нь бүгд нэр нүүрээс шалтгаална. Уригдан ирсэний хойно хэн хаана суух, хэн түрүүлж суух, хэн дараа нь суух, хэн гол суудалд сууж, хэн "бараа болох", тэр байтугай хэн хэний дэргэд зогсох хүртэл бүгд нэр нүүр лүгээ холбогдоно. Хоолны ширээнээ суусны дараа хэн түрүүлж ам хүрэх, хэн нь дараа нь хүрэх нь ч нэр нүүрийн хэрэг болно. Идээ ундаа зоогийн ширээ дүүрэн элбэг дэлбэг байж, ихэд хүндлэн дайлахуй нь зочны нэр нүүрийг өргөн хүндэлсэний илрэл болно. Тэгсэн атлаа "Хэр тааруухан дайлав, хичээн өршөөх ажаамуу" хэмээн ёс мэт заавал хэлнэ. Идээ ундаа элбэг дүүрэн бус, амт чанар

аанайхан тааруу байсан ч зочин хүмүүн урьж дайлсанд ихэд талархаж, идээ ундааны нь элбэг дэлбэгийг илт хоосон магтах нь урин залсан эзний нэр нүүрийг өргөхийн учир болно. Зоогийн ширээн дээрх идээ ундаанаас зэнзийрхэн эс хүртэх нь эзний нэр нүүрийг гутаасан хэрэг, амаа олохгүй, ааг амьсгаагүй ихээр идэх нь өөрийн нэр нүүрийг гутаасан хэрэг болно.

Хоол зоогт урихуйд шууд үгүй хэмээн татгалзваас урьсан тэр хүний нэр нүүрийг ихэд гутаасан хэрэг болно. Ер нь хятад хүн ямар ч үед шуудхан “үгүй” хэмээн эрс тэс татгалзах нь ер үгүй, тийнхүү шуудхан татгалзах нь нөгөө хүнийхээ нэр нүүрийг доромжилсонд тооцогдоно. Тийм болохоор хятад хүн аливааг шууд хэлдэггүй, ямагт тойруу замаар эерүүлж (委婉) илэрхийлдэг онцлогтой. Хятад хүн бусдын муу тал, гэм дутагдлыг шууд нүүрэн дээр нь хэлдэггүй, бусдын үзэл бодлыг эс зөвшөөрсөн ч шууд илэрхийлдэггүй. Тийм учраас хятад хүний санал бодлыг эрс тэс няцаах нь нэр нүүрийг нь эс бодсон хэрэгт тооцогдоно.

Хятадад очсон гадны хүний нүдэнд хүмүүс хоорондын харилцааны нэгэн дүр зураг хамгийн түгээмэл ажиглагддаг. Хэсэг хүн гаднаас гэр байшинд хамтдаа орохуйд хэн нэгнийгээ урдаа оруулж, өөрөө араас нь дагалдан орохын тулд өөр хоорондоо багахан хүч үзэж, дийлдсэн нь түрүүлж, дийлсэн нь араас нь дагаж орно, орсоны хойно хэн нь дээр, хэн нь доор суух суудал булаацалдан бас л багахан хүч үзнэ, тийнхүү ялсан нь доор сууж, ялагдсан нь дээр сууна, зоог барьсаны дараа төлбөр тооцоо хийх болохуйд бас л түрүүлж мөнгө төлөхийн тулд хүч үзнэ, ялсан нь мөнгийг төлнө, ялагдсан нь мөнгөний

хэтэвчээ буцаан өвөртлөх хэрэгтэй болно. Ийм дүр зургийг бид олонтаа хардаг. Харахад ойлгомжгүй мэт боловч нарийн ухваас бүхэлдээ бидний өгүүлэн буй “мианзы” буюу “нэр нүүр”-ийг ихэд чухалчилдаг бичигдээгүй олон “жаяг журам”-ын нэг, хүмүүс хоорондын харилцааны эш ёсны (ethics) хэм хэмжээний нэг илрэл нь энэ болой.

Хятад хүн гэр бүл хийгээд нийгмийн харилцааг байгаль ертөнц хийгээд бодот юмс үзэгдлээс илүүтэй чухалчлан үздэг. Бүр Күнзээс эхлэн хятадын үе үеийн сэтгэгчид хүмүүс хоорондын харилцааны учир холбогдлыг ихэд чухалчлан, “ээл, журам”, “сайн, муу”, “алдар, гутамшиг” гэхчлэн ёс суртахууны ай ухагдахууныг голчлон номолж, тэдгээр нь нийгмийн дэг ёс болж ирсэн уламжлалтай юм.

Нэр нүүр болвоос хүний амьдралын нэгэн зүйлийн зорьж тэмүүлэх, залж чиглүүлэх хөтлүүр хэмээмой. Нэр нүүрээ барж амьд явснаас нэртэй төртэй үхсэн нь дээр хэмээсэн эш суртал хятадын соёл сэтгэлгээнд өнө эртний уламжлалтай юм. Энэ тухай домог түүх өдий төдий байх агаад хамгийн алдартай нь “У мөрний газар Шян Юй хоолойгоо хэрчиж үхсэн түүх” (项羽乌江自刎) юм. Чинь улсын (秦朝) хожуу үеийн нэрт жанжин Шянь Юй хэмээгч нэгэн тулаанд ялагдсаны дараа У мөрний газар ухран хүрчээ. Түүнд загасчны завь онгоцонд сууж мөрний зүүнтээ орших улсдаа буцан очих боломж байсан хэдий ч тийнхүү буцан харихыг хүссэнгүй гэнэ. Тэрбээр “Буцан харьж нутгийн ахан дүүс, ахас ихэстэй уулзах нүүр үгүй болов” хэмээн хоолойгоо хэрчин өөрийгөө егүүтгэжээ. Тийнхүү нэр нүүрээ бодож амиа егүүтгэснээр харин ч нэр хүнд нь ихэд мандан тодорч, зориг

баатарлагийн үлгэр жишээ болж, алдар нэр нь ашид мөнхөрсөн хэмээдэг. Эндээс үзэхүл нэр нүүр хэмээхүй нь хятад хүний хувьд зарим тохиолдолд амь наснаас илүү үнэ цэнэтэй байдаг ажээ.

Бусдын нэр нүүрийг гутаан доромжилсоны харгайгаар улсаа мөхөөсөн түүх бас буй. Нэгэн бяцхан түүх өгүүлье.

Хавар, Намар, Байлдаант улсын үед олон ханлиг улс эрх мэдлийн төлөө арцалдан тэмцэлдэж байжээ. Чи улсын Хуань Гүн эрч зоригоо хөвчлөн, улс гэрээ засаж, Чи улс ч бусад ханлигуудын дотор хамгийн хүчирхэг нь болжээ. Чи улс Чин Гүний үед ихээхэн хүчирхэгжиж, Жинь, Лу, Вэй, Сао (晋、鲁、卫、曹) зэрэг бусад зэргэлдээ улс дагаар орж, жил бүр ихээхэн өргөл барьц өргөн барьдаг байжээ. Нэгэн жил дээрх 4 ханлиг улс нэгэн зэрэг 4 элч томилон, Чи улс руу илгээсэн байна. Гайхалтай нь дээрх 4 улсын элч бүгд зэрэмдэг хүмүүс байж. Жинь улсын элч нүд өрөөсөн, Лу улсын элч толгой хожгор, Вэй улсын элч хөл доголон, Сао улсын элч нуруу бөгтөр байж гэнэ. Чи улсын Чин Гүн зэрэмдэг элч нараар зориуд доог тохуу хийж, өөрийн эхийг баясгасугай хэмээн сэтгэжээ. Тийнхүү сохор, хожгор, доголон, бөгтөр хүн тус бүр нэгийг олж ирүүлж, элч нарыг зориуд асруулж харгалзуулжээ. Хатан эх хийгээд ордны эмс тэднийг хараад ихэд хөхин баясч, элдвээр элэглэн шоолж гэнэ. 4 улсын элчис нэр нүүрийг нь ихэд доромжлон гутаасанд машид уурлан хилэгнэж, Чи улсыг дайлан мөхөөх тухай зөвшин хэлэлцжээ. Тийнхүү 3 жилийн дараа, 4 улс нэгдсэн холбоо байгуулан, Чи улсыг их хүчээр дайлаар мордож, Чи улс ч ихэд ялагдан доройтож, дахин ер сэхээгүй гэдэг. Энэ болвоос бусдыг дорд үзэн, нэр

нүүрийг нь гутааж доромжилсоны хариуд хүртсэн гашуун сургамжийн тухай түүх юм.

Хятад хүн өөрөө бусдад ямар сэтгэгдэл төрүүлж буйгаа ихэд анхаарахаас гадна бусад хүн өөрийг нь хэрхэн үнэлж буйг машид чухалчилдаг. Бусад хүн өөрийг нь дорд үзэхийг ер тэвчдэггүй. Хэрэг дээрээ бусдаас дор байвч, түүнийгээ хүлээн зөвшөөрөхийг үл хүснэ. "Мод үндсээ гэмтэхээс эмээнэ, хүмүүн сэтгэл гэмтэхээс эмээнэ" гэсэн утгатай зүйр үг байдаг нь чухамдаа "нэр төрөө эрхэмлэх сэтгэл"-ийг өгүүлсэн хэрэг юм. Өрнө дахинд хувь хүний эрх чөлөөг ихэд эрхэмлэн, өөрөө өөрийгөө ямагт тэргүүнд тавин, бие даасан бодгаль хэмээн үздэг бол хятад хүний хувьд бусад хүн өөрийг нь хэрхэн үзэж буйг эн тэргүүнд чухалчилдаг. Өрнийн хүний "нэр төрөө эрхэмлэх сэтгэл" нь "хүн хүн өөрийн замаар, бусад хүн намайг юу гэх нь ер хамаагүй" гэсэн маягаар илэрдэг бол, хятад хүний хувьд бусдаар бахдуулж, бусдын бахдал, үнэлэмжийг олсноор "нэр төрөө эрхэмлэх сэтгэл" нь илэрдэг байна. Тиймийн учир "Бусдыг бахдах нь хүний эрхэм дээд ёс суртахууны нэг" хэмээн үздэг. Бусдыг бахдах нь нэгэн зүйлийн эрхэм ёс суртахуун, нэгэн зүйлийн соёл, нэгэн зүйлийн чадвар, бас орчлон ертөнцөд оршин амьдрахуйн нэгэн арга зам хэмээн үздэг.

Хүмүүн хэмээх амьтан ямагт бусдаар бахдуулж, магтуулах орь хүслэнгээр бялхаж байдаг ажгуу. Тиймээс бусдын бахдлыг хүртэж, тэрхүү бахдуулах орь хүсэл нь биелэхийн цагт "нэр төрөө эрхэмлэхүйн сэтгэл" нь огшин дэвэрч, гүн чанадад нуугдан асан олон далд чадавхи нь оргилон буцалж, олон олон гайхамшигийг бүтээдэг ажээ. Тийм болохоор хүмүүс хоорондын харилцаанд бие

биенээ бахдан, бахархахуй болвоос түмэн өнгийн цэцэг алаглахуй мэт, тунгалаг булгийн уснаа саран гэрэлтэхүй мэт эрхэм чухал зүйл хэмээн үздэг бөлгөө.

Аль ч үндэстэн ард түмэн бүгд нэр нүүр, нэр төрөө машид эрхэмлэн дээдэлдэг нь магад үнэн боловч хятад хүн тэдний дотор лав толгой цохино хэмээн судлаачид бичсэн нь буй. Хятад хүн нэр нүүрээ хамгаалахын төлөөнөө оюун санааны хийгээд бодот хохирол амсахаас ер эс айх бөгөөд нэр нүүрээ алдах нь ичгүүр гутамшиг хэмээн үзэж, алдсан нэр төрөө эргүүлэн олж авахын тулд амь насаа золихоос ч буцдаггүй хэмээнэ. Тиймийн учир хятад хүнтэй харилцахуйд эн тэргүүнд нэр нүүрийг нь машид эрхэмлэх нь туйлын чухал болой. Хэрэв хятад хүний нэр нүүрийг нь нэгэнтээ гутаах аваас дахин түүнтэй нүүр учран нөхөрлөх тухай бодохын ч хэрэггүй болно.

Хятад хүний “нэр нүүр” хэмээх ухагдахууны тухай ярих аваас хятадын нэрт зохиолч Лу Шүнь-ий (鲁迅) “А Кьюгийн үнэн түүх” (阿 Q 正传) хэмээх алдарт зохиолын тухай заавал ярих хэрэгтэй болно. Хятад хүний сэтгэл зүйн өвөрмөц онцлог, нэр төрөө эрхэмлэдэг үзэл санааг машид амьдлаг, тод томруун дүрслэн харуулсан бүтээл бол Хятадын шинэ цагийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг, нэрт уран зохиолч, сэтгэгч Лу Шүнь-ий (1886-1936) 1921 онд туурвисан “А Кьюгийн үнэн түүх” хэмээх зохиол юм. Энэ зохиолд “А Кьюгийн үзэл санаа” хэмээх ухагдахууны тухай дурдан өгүүлсэн байдаг. Энэхүү алдарт зохиолыг манай ахмад орчуулагч Ж.Артөр хятад хэлнээс монголчлон орчуулж олны хүртээл болгосон билээ.

Лу Шүнь аругайн дүрслэн өгүүлсэн А

Кью хэмээгч нь гэр оронгүй, ажил төрөлгүй, туйлын ядуу нэгэн юм. Овог нэр, уугуул нутаг усыг нь хэн ч үл мэдэх төдийгүй, урьд өмнийн ажил үйлсийг нь хэн ч үл сонирхоно. Тэрбээр сүмд хоног төөрүүлж, амьтан хүнд аар саар хар бор ажил хийж, өл залгана. Вэй хэмээх тосгоныхон ажил төрөл ихсэж, яаруу давчуу болох үед л зарах гэж түүнийг санахаас бус, бусад үед ор тас мартаж орхих ажээ.

Тийм бөгөөтөл А Кью биеэ ихэд өргөмжлөх агаад Вэй тосгоныхныг нэг нүдээр эс харна. “А Кью ...хүнтэй ам нээвэл л нүдээ дүрлийлгэн: “Миний өвөг дээдэс чинийхээс хол илүү. Чи юу юм?” хэмээх ажээ. Тэрбээр цаг ямагт өөрийгөө өндөрт өргөн, өөрийн биеийг бусдаас ер дутахгүйгээр үл барам, хол давуу хэмээн сэтгэж, тэгснээрээ сэтгэл ханаж, таашаал хүртэх ажээ. А Кью нэгэнтээ “хоёр тагш дарс балгаад, өөрийгөө бас өндөр нэр алдартай хүн хэмээн өгүүлж, учир нь миний бие эрхэм Жао-тай овог ижил, нарийвчлан үзэхүл би бичиг номын оюутнаас гурван зэрэг дэв давуу” хэмээн сайрхдаг билээ. Маргааш нь Жао эрхэмд “Чам мэтийн амьтан яаж надтай овог нэгтэй байдаг юм?” хэмээн зад загнуулж, дээр нь алганы амт үзэн, алгадуулаад буцахдаа ялан дийлсэн мэт сэтгэн ханан, ер эс дуугарах бөлгөө. А Кью бусдад байнга зодуулах агаад өөдгүй этгээдүүд үснээс нь зуурч, хана хэдэнтээ мөргүүлж бах таваа хангаад яваад өгөхөд тэрбээр харин “хүүдээ зодуулав” хэмээн бодож, сэтгэл ханаж, дотроо ялан дийлсэн мэтээр сэтгэнэ.

Зохиолд өгүүлснээр, А Кью тийнхүү “уран аргаар заналт дайснаа дийлсэний дараа хөгжилтэй гэгч нь архины мухлаг руу гүйн очиж, хэдэн тагш дарс уугаад бусадтай алиа марзан үг хэлэлцэн, хэл ам зөрж, дийлж аваад

баяртайяа сүм рүүгээ эргэн хүрч, толгой тавиадунтаад өгөх” ажээ. Ийм үйлдэл төрхийг нэрт зохиолч Лу Шүнь “сэтгэл санаагаар ялан дийлэх арга” (精神上的胜利法) хэмээн томъёолсон байдаг. Тийнхүү бодот байдал дээр ялж дийлж эс чадахуйд өөрөө өөрийгөө тайтгаруулан, ялагдлыг ялалт мэтээр сэтгэхийг “сэтгэлээр ялан дийлэх арга” буюу “сэтгэл зүйн ялалт” (psychological victory) хэмээх бөгөөд хятадын эртний түүх шастир, бичиг зохиолд энэ тухай өгүүлсэн нь цөөнгүй тааралддаг бөлгөө. А Кью эрхэм Жаогийн “алганы амтыг үзсэнээс хойш өөрийгөө ихэд нэр цууд гарав” хэмээн сэтгэж, “Одоо ертөнц хорвоо горьгүй болж, хүү нь эцгийгээ зоддог болж байна...” хэмээн бодолхийлэх ажээ. Тийнхүү сүр хүчтэй Жаог хүүгээ болгон дүрслэснээр аяндаа сэтгэл ханан баясах ажээ. Тэр “ялагдахын зовлон гээчийг нэлээд амсах” атлаа “харин төдхөн ялагдал нь ялалт болон хувирна. Баруун гараараа нүүр рүүгээ хоёр ч удаа алгадаад орхиход нь халуу оргин, зүгээргүй өвдөж, сая сэтгэл нь тайвшран, өөрөө өөр хүнийг цохих шиг санагдана. Удалгүй өөр бусдыг цохьсон янзтай, хэдий халуу оргин өвдөж байвч, ялсандаа сэтгэл өөгшин хэвтэж нойрсох” ажээ.

А Кью “нэр нүүр”-ийг ихэд эрхэмлэн, бусдын дор орохыг үл тэвчихийн учир сахалт Ван хэмээгчийг ихэд үзэн ядна. Учир нь А Кью өөрөө сахалгүй нэгэн ажгуу. Тийнхүү сахалт Ван хэмээгчийг өдөж, түүнд нэвширтэл зодуулна. А Кью-гийн хамгийн их үзэн яддаг жигшүүрт этгээдийн нэг нь Цянь хэмээгчийн ууган хүү ажээ. Учир нь тэр Японд очиж, хагас жилийн хойно эргэж ирэхдээ үс гээггүй болсонд А Кью түүнийг “гадаадын хуурамч чөтгөр” хэмээн нэрлэж, дотроо харааж зүхэх

ажээ. Тэр “далайн хуурамч чөтгөрийг” бас өдөж хоргоож байгаад өөрөө нэвширтлээ зодуулна. А Кью энэ насандаа тийнхүү хоёр удаа ихэд нэр нүүрээ барж, доромжлол үзэх мэт санагдавч, төдхөн сэтгэл нь онгойж, хөгжүүн цэнгүүн болох бөлгөө. Тэгтэл сүмээс нэгэн атигар гэлэнмаа гарч ирэхүйд А Кью түүнийг угтан очиж элдвээр доромжилно. Уг нь гэлэнмааг доромжлох нь нэр нүүрээ барсан хэрэг атал А Кью харин нэр төрийн хэрэг хэмээн үзэх ажээ. Учир нь архины мухлагт буй дэл сул хүмүүс түүний тийнхүү аяглахыг хараад хөхин баясч, хөөрөгдөн дөгөөх ажгуу. “Архины мухлагт байх тэрхүү дэл сул хүмүүс угаасаа олонхи нь тийм ч их нэр нүүртэй гэж хэлэхээргүй хүмүүс тул өөрсдөөс нь илүү нэр нүүргүй нэгэн тийн бусдыг доромжлохыг бахдан хараад харин ч өөрсдийгөө нэр нүүртэй хүмүүс мэтээр сэтгэн, тийнхүү ихэд “хөхин инээлдэх” ажгуу. Тэдний тийнхүү хөхин баясч, хөөрөгдөн уухайлах нь А Кью-гийн хувьд “нүүр хайрласан”, “нүүр тал өгсөн” хэрэг тул бас ихэд сэтгэл ханан, хөхин баясах ажгуу” хэмээн профессор И Жунтянь бичсэн байдаг.

Тийнхүү А Кью хэдийвээр сахалт Ван, “гадаадын хуурамч чөтгөр” нарт доромжлуулсан “нэр нүүрээ олж”, “тэр өдрийн бүх аз хийморьгүй хэрэг явдлын өшөө хонзонг авсан” мэт боловч гэлэнмаад бас “үр хойчис үгүй, үндэс угсаа нь тасарсан заяагүй А Кью” хэмээн хараалгах бөлгөө. А Кью эцсийн эцэст хулгай дээрэмд хилсээр хардагдан, “нэгийг гэсгээж, нийтэд цээрлэл болгох”-ын төлөөсөнд толгойгоо авахуулах болж, бичиг үсэг мэдэхгүйн учир цаазын бичигт дугуй дүрс зурахдаа, хүн шоолохоос эмээн, аятайхан дугуй зурах гэж ихэд

хичээсэн боловч, тийн зурж чадалгүй зууван дүрс зурсандаа ичиж зовох бөлгөө. Тэнгэр газрын хооронд хүн болж төрөөд шоронгийн өрөөнөөс чирүүлж гарч, түлхүүлж орох, заримдаа цаасан дээр дугуй зурах нь зүй ёсны хэрэг, харин дув дугуй дүрс зурж чадалгүй, зууван дүрс зурсандаа ичиж зовон, "нөхчсөний дараах намтар бичиг"-т (行状) нь хар толбо болж үлдэх вий хэмээн сэтгэл зовинон бодсоор байдаг билээ. Тийнхүү А Кью-г бүрхүүлгүй тэргэн дээр чирэн гаргаж, бусдыг айлгаж сүрдүүлэхийн тулд тосгоны гудамжаар тойруулж удаан явахад ганц ч үг дуугаралгүй, нэг ч дуу дуулалгүй явсаар толгойгоо авахуулдаг бөлгөө.

Нэрт зохиолч Лу Шүнь энэхүү зохиолдоо А Кью хэмээгч ядуу эрийн өөрийн эмгэнэлт амьдралыг бодтойгоор харж чаддаггүй, өөрийгөө ямагт өндөрт өргөн, өөртөө хий хоосон нэр төрийн "баг халхавч" зүүж, сэтгэлээ тайтгаруулан, "ялагдал доромжлолыг ялалт" мэтээр дүрслэн сэтгэдэг тийм сэтгэл зүйн гэм согогийг шог хошиноор ёгтлон шүүмжилж, энэ болвоос "улс үндэстний сул дорой шинжийн илрэл" хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, А Кью хэмээх "хэв шинжит дүрийг" бүтээж, уг дүрээр хятад үндэстний зан чанарын нэгэн сул дорой шинжийг дүрслэн өгүүлсэн нь энэ болой. Хятадын орчин үеийн нэрт зохиолч Мао Дүн бичихдээ, "А Кью болвоос нэг талаар хятад хүний зан чанарын үр бүтээл, нөгөөтэйгүүр бас зөвхөн хятад үндэстний өвөрмөц дүр хэмээхийн аргагүй, хүн төрөлхтөний нийтлэг султалмэт" хэмээн бичжээ. Үүнийг хэдийвээр сул доройн шинж, нэгэн зүйл гэм согог хэмээн үзэх боловч, нөгөө талаар аливаа хүмүүн олон туйлт ертөнц дээр оршин тогтнож, нийгэм

хийгээд хүмүүс хоорондын ээдрээ төвөгтэй олон зүйлийн харилцаан дунд өөрийн биеийг ямагт сэргэмжлэн, учирч болох гай зовлон, гамшиг барцадыг зөөллөн холдуулж, өөрөө тэсч үлдэхүйн нэгэн арга хэмээнэ.

Гагцхүү хэм хэмжээ нь хэтрэх дутуудахын ёсноос хэтэрч халих аваас "өөрийн биеийг хуурч, өрөөл бусдыг мэхэлсэн" өнгөн төдий, инээдэмт хэрэг болон хувирах ажгуу.

Гэвч "нэр нүүр" буюу "нэр нүүрээ эрхэмлэх" сэтгэл зүйг зөвхөн гэм согог хэмээн үзэж, дан гагц сөрөг талаас нь үнэлж цэгнэвээс бас учир дутагдалтай болно. Нэр нүүр болвоос хүмүүс хоорондын харилцааны нэгэн "нэвтрэх түлхүүр" хэмээн үзнэ. Ёс зүйг чанд сахин, хэм хэмжээний хүрээ хэвчээний дотор нэр төрөө дээдлэн эрхэмлэхүй нь ямар ч улс үндэстний бие даан оршин тогтнохын нэг үндсэн нөхцөл ажээ.

"Хүчтэний өмнө хүчгүй нь хэзээд буруутан" болдог, тийн дарагдавч толгой үл гудайн, дийлдсэн ч дийлсэн мэт дүр эсгэн, "хар гэртээ хаан, бор гэртээ богд" хэмээн өөрийгээ сэтгэж, бусдын дор хэзээ ч үл орох үзлээр бие сэтгэлийг тэтгэх, нөгөөтэйгүүр нэр нүүрийг ихэд хичээн, "нэр хугарахаар яс хугар" хэмээн сургаж, "нэр төрөө барах"-аас ихэд цээрлэн, нэр ашгийн төлөө нэгэн биеийг золихоос ч эс буцах, энэ бүхэн нь үндэстэн ястан, арьсны өнгө, цаг үе, орон зайнаас үл хамааран, нийт хүн төрөлхтөнд нийтлэг оршин байдаг нэгэн дүр төрх гэнэм.

Хятадын нэрт кино найруулагч Жан Имоу (张艺谋)-гийн 1992 онд бүтээсэн "Чиү Жүгийн зарга" (秋菊打官司) хэмээх дотоод гадаадад ихэд алдаршсан нэгэн кинонд хятад хүн "нэр нүүрийг" хэр зэрэг эрхэмлэдгийг дүрслэн харуулсан байдаг. Уг кино Италийн

Венецийн 49 дэх удаагийн кино наадмын шилдэг киноны шагнал зэрэг олон нэр хүндтэй шагнал хүртжээ. Кинснд Хятадын хөдөө тосгоны Чиү Жү хэмээх нэгэн жирийн бүсгүй нэр төрөө хамгаалан хэрхэн заргалдсан түүхийг өгүүлдэг юм. Чиү Жү-гийн нөхөр нь тосгоны даргатай бяцхан маргалдаж, хараан зүхсэнд тосгоны дарга уурлаж, өшиглөсөнөөс болж яльгүй бэртэж гэмтэнэ. Тэр даруй эмчлүүлж эдгэрэн, бүх хэрэг сайнаар шийдэгдэх агаад харин тосгоны дарга биеэр ирж, бэлэг сэлт барьж, уучлал гуйхыг үл хүснэ. Чиү Жү тосгоны даргыг заавал ирж, уучлал гуйх ёстой хэмээн үзнэ. Аль аль нь нэр төрөө эрхэмлэхийн учир тийнхүү бяцхан зарга заальхай үүсэх ажээ. Угтаа Чиү Жү-гийн гэрийнхэн хийгээд тосгоны дарга хоорондоо маш сайн харилцаатай хүмүүс байдаг. Чиү Жү амаржих болж, дуншиж эхлэхэд нь тосгоны дарга сандран тэр даруй хүмүүс дайчилж, тосгоноос маш хол орших эмнэлэгт түүнийг яаравчлан хүргүүлснээр эсэн мэнд амарждаг. Чиү Жү тосгоны даргын халуун сэтгэлийг ихэд бишрэн талархана. Тэгсэн атлаа эрс шулуун зантай тэрбээр урьдын адил тосгоны даргыг өршөөл уучлал гуйх ёстой хэмээн үзсээр, бүх шатны шүүх, засаг захиргааны янз бүрийн байгууллага газраар цөхрөлтгүй явж, зарга мэдүүлнэ. Аль нэгэн холбогдох хуулийн хийгээд захиргааны байгууллагаас түүнд ямар нэгэн "хариу" өгч, тосгоны даргын тэрхүү үйлдэл нь "хууль бус", "таных зөв" гээд л хэлчихвэл бүсгүйн цорын ганц зорилго нь биелэх аж. Бүсгүйн тийнхүү олон газрын хаалга татаж, цөхрөлтгүй явахын гол утга учир нь өөрийн гэр бүлийн нэр нүүрийг хамгаалж эрхэмлэх явдал болно. Киноны үйл явдал агуулгаас нь харахад ялимгүй хэрэг

явдлын тухай өгүүлэх мэт боловч чанад гүнд нь хятад хүний "нэр нүүрээ эрхэмлэх" үзэл санаа нэвт сүлэлдэж байдаг билээ.

Хятад хүнийн хувьд нэр нүүртэй байх аваас уул тааралдсан ч давах зам олдоно, ус тааралдсан ч гатлах гүүр олдоно хэмээн үзэх агаад хүнд бэрхийг хөнгөн хялбар болгож, хамаг хэрэг харшлах саадгүй бүтнэ, хортон дайсан ч анд нөхөр болон хувирч, аюул түгшүүрийг ч амгалан төвшин болгож чадна хэмээн үзнэ.

Профессор И Жунтянь "Хятад хүний тухай сул яриа" номдоо "Хүмүүс "албаны арван тамгаас ганц зурвас дээр" хэмээн хэлцдэг. Хятад хүн гадагшаа гарч, ажил төрөл хөөцөлдөх болвоос хэн нэгэн нэр нүүртэй хүнээр хэдэн захидал зурвас бичүүлж (Дээр үед үүнийг "найман мөрт захидал" (八行书) хэмээн нэрлэдэг байв) арга барагдаж ягтах үед хэрэглэхээр биедээ авч явдаг" хэмээн бичсэн байна.

Их сэтгэгч Мэнз "Тэнгэрийн дор туйлын хүндлэлтэй нь гурав буй, тэр болвоос эрх хэргэм, өндөр нас, эрхэм суртал болой" хэмээн номлосон байдаг. Хятад хүн нэр нүүрийг эрхэмлэхдээ өндөр нэр нүүртэй эрхэмийн нөмөр нөөлөгт түшиглэхээс гадна, нөгөө хүнийхээ нэр нүүрийг хүндлэн ямагт өөд нь өргөдөг онцлогтой. Нөгөө хүнийхээ нэр нүүрийг өргөх нь өөрийн нэр нүүрийг дээдлэхтэй эн тэнцүү хэмээн үзнэ. Тухайлбал, хятад хүн өөрийн бичиж туурвисан ном зохиолоо бусдад бэлэглэн барихдаа "эрдэм төгс хүмүүн", "билгийн мэлмий хурц" гэхчлэн хүндэтгэлийн үгсийг голчлон дурдах бөгөөд "толилон соёрхох ажаамуу" (雅正) хэмээн заавал бичнэ. Энгийн логигоор бол энэ нь номоо барьж буй хүнийг "эрдэм төгс" хэмээн

дээдлэн магтсанаар өөрөө түүнээс эс дутахын учрыг бас давхар өгүүлж, бусдыг магтсанаар биеийг өргөж буй хэрэг болно. Бусдын хүндлэл, өргөмжлөл, магтаалыг хүртсэн хүн баярлаж хөөрөх нь мэдээж. Хэрэв ёс зүйг эрхэмлэдэг хүн байваас баярласан сэтгэлийн хариуг заавал барих агаад тийнхүү харилцан нэр нүүрийг эрхэмлэх "гинжин хэлхээ" үүсдэг ажгуу. Тийм учраас хятад хүн "Хүн намайг тохой хүндлэх ахул, би хүнийг алд хүндэлмой" хэмээн өгүүлдэг бөлгөө.

Хятад хүн яриа хэлэлцээ хийх, илтгэл үг хэлэх, ажил хэрэг хэлэлцэх үед үзэл бодлоо илэрхийлж, санал санаачлага дэвшүүлэхийн өмнө заавал ёс мэт сайшаасан, магтсан өнгө аяс бүхүй "оршил" үг хэлж, дараа нь жинхэнэ санал бодлоо илэрхийлнэ. Тийм учраас гадаадынхан анх удаа хятад хүнтэй нүүр тулан ярилцаад учир жанцанг нь эс ухан, хятад хүн худлаа хоосон үг хэлэх дуртай, зүрх сэтгэлийн үгээ хэлдэггүй, заль мэх гаргадаг гэхчлэн ойлгоход хүрдэг тал буй. Уг чанартаа бол тэрхүү тойрч дөлсөн үг яриа нь хий хоосон үг ч биш, хэрэггүй дэмий яриа ч биш, бусдын нэр нүүрийг бодож, тал өгсөний нэг илрэл ажгуу. Хятад хүн "би зөвшөөрөхгүй", би эсэргүүцэж байна" хэмээн эрс тэс илэрхийлэх нь нөгөө хүнийхээ нэр нүүрийг үл хүндэтгэсэн хэрэг хэмээн үздэг учраас тийнхүү "оршил" үг заавал хэлдэг байна.

Хятад хүний "нэр төрөө эрхэмлэхүй" нь аливаа жам ёс, зүй тогтлын нэгэн адил эерэг сөрөг хоёр талтай хэмээнэ. Юуны өмнө "нэр нүүр" болвоос хүн төрөлхтөний соёл иргэншлийн нийтлэг нэгэн шинж ажгуу. Нэр нүүр нь хүмүүс бие биесээ харилцан хүндэтгэх нийгмийн дадал заншил бүрэлдэн тогтох хийгээд хүмүүс хоорондын харилцааг

зохицуулах хэрэгт нэн тустай ажээ.

Английн философич Бертрэнд Рассел/ Bertrand Russell/ 1922 онд бичсэн "Хятадын асуудал" хэмээх номдоо "Гадаадын хүмүүс хятадын "нэр нүүрээ эрхэмлэх"-ийг инээдэмтэй зүйл мэтээр үздэг. Харин энэ нь чухамдаа нийгэмд бие биесээ харилцан хүндэтгэх уур амьсгал бүрдүүлдэг болохыг бодож үзсэн нь ер үгүй" хэмээн бичжээ.

Хятад хүний сэтгэл зүрхэнд "нэр нүүр" нь алдар хүнд, байр суурь, амжилт бүтээл хэмээн төсөөлөгддөг байна. Тэр утгаараа "нэр нүүрээ бодох" нь нэг талаар нийгмийн хийгээд хувь хүний ёс суртахууны хэм хэмжүүр, нөгөө талаар цээр хориг болж байдаг. Тийнхүү нэг талаар "нэр нүүрээ бодож" нийгэм хийгээд хүмүүст тустай сайн үйл бүтээхийг чухалчилж, нөгөө талаар "нэр нүүрээ алдах"-аас эмээн хортой муу үйлээс хол хөндий явахыг хичээдэг ажээ. Тийнхүү нийгэм хийгээд хүмүүсийн харилцаанд эе зохирёлыг (和谐) буй болгодог байна.

Түүнчлэн "нэр нүүрээ эрхэмлэхүй" нь хүмүүний ичиж зовох сэтгэлийг үүтгэдэг ажгуу. Ичиж эмээх сэтгэл үгүй аваас ямар ч ёс суртахууны тухай ярих хэрэггүй болно. Энэ нь "нэр нүүрээ эрхэмлэдэг" тэр л сэтгэл зүй лүгээ салшгүй холбоотой юм. Хүмүүс хоорондоо харилцан хүндлэлтэй байж, нийгэм бүхэлдээ эе зохиролтой оршин тогтнохуйд "нэр төрөө эрхэмлэхүй" үзэл нэн чухал нөлөөтэй хэмээхүй нь учир энэ ажгуу

Гэвч "нэр төрөө эрхэмлэхүй"-д сөрөг муу тал, гэм согог бас буй хэмээнэ. Хятадад "нэр нүүрт хэт шунаваас, гай зовлон үүдмүй" (死要面子活受罪) хэмээсэн мэргэн үг байдаг нь чухам үүнийг өгүүлсэн хэрэг юм. Хятадын эрдэмтэд судлаачдын бичсэнээр, тэрхүү гэм

согог, сөрөг тал нь юуны өмнө хятад хүний ший жүжиг мэт сэтгэлгээний арга маягаар тод илэрдэг байна. Ерөөсөө уламжлалаас үзэхүл, хятад хүн ший жүжигт маш дуртай ажээ. Хятадын уламжлалт нийгэмд бүхий л улс даяар түгэн дэлгэрэхэд хамгийн дөхөм цорын ганц наадам цэнгээний төрөл зүйл нь ший жүжиг байсан гэдэг. Хятад хүний сэтгэлгээний ший жүжиг мэт арга маяг хэмээх нь үүнтэй холбоотой ажээ. Ший жүжгийг янз бүрийн байр талбайд, янз бүрийн баг халхавч өмсөж тоглох агаад жүжгийн үг яриа, үйл хөдлөлөөр янз бүрийн дүрийг дүрслэн харуулна. Тэдгээр нь ихэнхдээ бодтой бус, голдуу хуурмаг шинжтэй, чухамдаа "ууранд хийгээд оногдох нь үгүй, уутанд хийгээд баригдах нь үгүй" тийм дүр байдаг хэмээнэ.

Тиймийн учир "нэр нүүрээ бодох" явдал хэрээс хэтрэх аваас нэг талаар хүмүүс хоорондын хэвийн харилцаа ээдрээ төвөгтэй болж, олон бэрхшээл төвөг учирдаг байна. Хүмүүс бусдын "нэр нүүр"-ийг бодохын эрхээр өөрийн хүсэл зоригоо хязгаарлаж, орчлон ертөнцөд оршин тогтнохуйн жаяг зарчмыг арга буюу зөрчихөд хүрдэг аж.

Нөгөө талаар "нэр нүүрээ эрхэмлэхүй" нь нийгэмд хэлбэрдэх суртлыг буй болгодог байна. Учир нь "нэр нүүр" хэмээх нь бусдад хэрхэн үнэлэгдэхээс голлон шалтгаалахын учир агуулгыг бус хэлбэрийг чухалчлахад хүргэдэг ажгуу. Бусдын баяр талархал, магтаал сайшаалыг олохын тулд аливаа ажил хэргийн бодот шинж чанарыг бага анхаарч, өнгөн талын хэлбэрийг илүүтэй чухалчлахад хүрнэ. Тиймээс нийгэмд түгээмэл оршин байдаг хэт ёсорхох, хоосон баярхах, үрэлгэн загнах, мугуйдлан атаархаж, зиндаархах зэрэг олон үзэгдэл нь хятад хүний "нэр нүүрээ

эрхэмлэхүй" сэтгэл лүгээ нягт холбоотой байдаг ажгуу.

Эцэст нь "нэр нүүрийг эрхэмлэхүй" нь аливаа асуудлыг бодтой, шударгаар, эрх тэгш, хууль журмын дагуу шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлдөг байна. Өнөөгийн нийгэмд амь бөхтэй оршин байгаа идэж шамшигдуулах, авлига, хээл хахууль авах, хууль цааз зөрчих зэрэг хортой үзэгдлүүд нь мөнхүү "нэр нүүр харах" сэтгэл зүй лүгээ зайлшгүй холбогддог ажгуу.

Хятад орон өнөөдөр шинэтгэл нээлттэй бодлого хэрэгжүүлэн, улс төр нь тогтвортой, эдийн засаг нь эрч хүчтэй цойлон хөгжиж, Хятад улсын мандан бадрал (中国崛起) дэлхийд гайхагдаж байна. Хятад орон дэлхийн ертөнцөд улам бүр нээлттэй болж, дорно өрнийн соёл эсэн найрсаж, хятад хүний уламжлалт соёл сэтгэлгээ, түүний дотор "нэр нүүрээ эрхэмлэдэг" чанар нь олон зууны уламжлалаа хадгалахын зэрэгцээ, цагийн аясаар хувиран шинэчлэгдэж, сөрөг, муу тал нь улам бүр хумигдан багасч, эерэг сайн тал нь өргөжин тэлсээр, шинэ шинэ агуулгаар баяжин, шинэ үеийн шинэ хятад хүн (新新人类) бүрэлдэн буй болж байна.

НОМ ЗҮЙ

1. 叶朗 朱良志 著 中国文化读本 北京 2008年
2. 楼宇烈 著 中国的品格 海南出版公司 2009年
3. 易中天 著 闲话中国人 上海文艺出版社 2007年
4. 鲁迅 著 阿Q 正传 外文出版社 2009年
5. 吕 Синь "Буяны ерөөл" орчуулсан Ж.Артөр УБ 1985 он